



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/470

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2.а, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” 03/02 дугаар тогтооын 2.2.5.5 дахь заалт, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 2.2.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит байгууллагуудын ашиглалтгүй барилгуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Тарагт, Бүрд сумдын Ерөнхий боловсролын сургуулийн хөрөнгөд бүртгэлтэй хуучин Дотуур байрны барилга, Есөнзүйл сумын Ерөнхий боловсролын Тахилга бага сургуулийн барилга, Дотуур байр гал тогооны барилга, 440 хүүхдийн хичээлийн байрны барилга, Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газрын Зочид буудлын барилга, Соёлын төвийн хуучин барилгуудыг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлсэн үнэлгээний зардалд 4,200,000 (дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100997

D:My Doc. Zahiramj. Zasag darga